



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/327

Улаанбаатар хот

Согтууруулах ундаа худалдах, түүгээр
үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.8, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30.1, 30.2 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/847, 2024 оны А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/244 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2025 оны 11 дүгээр хурлын тэмдэглэлийг үндэслэн спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл шинээр олгох 4 хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох 1 хуулийн этгээдийг хоёрдугаар хавсралтаар, хаяж үрэгдүүлсэн тусгай зөвшөөрлийг дахин олгох 1 хуулийн этгээдийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгогдсон хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (Б.Номин), Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар (Ц.Амгалан-Энх), дүүргийн 1-24 дүгээр хорооны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Үнэт цаасны бичилт, олголт, хураамжид байнгын хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхбаяр), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010971